

ХУРЛЫН НЭЭЛТИЙН ҮГ

*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал,
доктор (Ph.D), дэд профессор Д.ЗОЛБОО*

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Юуны өмнө бид бүхний урилгыг хүлээн авч, "Олон улс судлал 2022: Монголын Япон судлал" эрдэм шинжилгээний хуралд оролцохоор хүрэлцэн ирсэн эрхэм хүндтэй эрдэмтэн, багш, судлаач та бүхэндээ талархал илэрхийлье.

"Олон улс судлал" эрдэм шинжилгээний хурал 2000 оноос жил бүр зохион байгуулагдаж байсан уламжлалыг сэргээж, 2019 эхлүүлэхээр төлөвлөсөн ч, цар тахлын улмаас нэг жилээр хойшлогдож, 2020 онд "Монголын Хятад судлал", 2021 онд "Монголын Орос судлал" эрдэм шинжилгээний хурлыг тус тус зохион байгуулж, хурлыг эмхэтгэлийг хэвлүүлж гаргасан билээ.

Энэ жилийн хувьд мөн онцлог жил болж байгаа нь Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиож буй явдал болно. Энэ хүрээнд манай хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын салбарын япон судлаачдаас *"Монгол, Японы харилцаа он дарааллын товчоон (1972-2022 он)"*, *"Монгол, Японы харилцаа баримт бичгүүд (1972- 2022 он)"* зэрэг судалгааны чухал хэрэглэгдэхүүн болох архивын баримт бичгийг эмхэтгэн гаргасан нь цаашид манай улсад Япон судлалыг өргөжүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гэж бодож байна. Мөн хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрч стратегийн түншлэлд хүрч байгаа энэ цаг үед "Гуравдагч хөрш"-ийн байр суурь тэргүүн зэрэгт явдаг гэдэг утгаараа "Олон улс судлал-2022: Монголын Япон судлал" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байгаадаа баяртай байна.

Тус хүрээлэнгийн үүсэл 1968 онд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэд Ази, Африк судлалын хэлтэс нэртэйгээр байгуулагдсан цагаас Монголын Япон судлал тасралтгүй хөгжсөөр өдийг хүрсэн билээ. Энэ түүхэн хугацаанд хүрээлэнд ажиллаж байсан үе үеийн ахмад судлаач нараа хүндэлж явдгийн хувьд тэдний залгамж халааг алдагдуулахгүй, цаашид улам өргөжүүлэн хөгжүүлэх нь бидний туйлын хүсэл юм. Монголын Япон судлалын түүх, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага

хэрхэн тодорхойлогдох нь судлаач бид бүгдээс шалтгаалах учир уламжлалаа хадгалж, Япон судлалыг хөгжүүлэх үйлсэд хувьд нэмэр оруулж байгаа судлаач та бүхэнд цаашдын судалгааны ажилд амжилт хүсье.

Өнөөдрийн бидний зохион байгуулж буй эрдэм шинжилгээний хурал өргөн сэдвийн хүрээнд сонирхолтой олон илтгэл хэлэлцүүлсэн, зохих үр дүн гарсан эрдмийн үйл ажиллагаа болно гэдэгт итгэж байна.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.